



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2018 оны 04 сарын 11-ны  
өдрийн 367 дугаарт бүртгэгд.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 07/04

Арвайхээр

Төлбөрийн хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "д", Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон нутгийн авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.
2. Орон нутгийн авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн хэмжээг мөрдүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 9/01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн  
07/04 дугаар тогтоолын хавсралт

**ОРОН НУТГИЙН АВТОЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ  
АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

/төгрөгөөр/

Нэг.	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл	Төлбөрийн хэмжээ	
1.1	Мотоцикл	3000	
1.2	Суудлын автомашин /хөдөлгүүрийн багтаамжаар/	2001 см3 хүртэл	10000
		2001-3001 см3	15000
		3001 см3 болон түүнээс	20000
1.3	Автобус	14 хүртэл хүний суудалтай	20000
		45 хүртэл хүний суудалтай	30000
1.4	Ачааны автомашин /даацаар/	1,5 тн хүртэл	20000
		1,5-5 тн	25000
		5-10 тн	30000
		10-20 тн	20000
		20 тн-оос дээш	30000
1.5	Тусгай зориулалтын өөрөө явагч хэрэгсэл	20000	
1.6	Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл	15000	
1.7	Чиргүүл /даацаар/	5 тн хүртэл	10000
		5 тн болон дээш	20000
1.8	Бага оврын трактор	8000	
Хоёр.	Нийтийн эзэмшлийн авто зогсоолууд	төлбөргүй	

---oOo---